

БА маркын ажлын зургийн бүрдэлийн жагсаалт

Д/д	Хуудасны нэр	Хуудасны марк
1	Зургийн жагсаалт, тайлбар бичиг	ББ-1
2	Суурийн байгуулалт, огтлол, түүвэр	ББ-2
3	Ханын торны байгуулалт хэсэглэл	ББ-3
4	Ялууны байгуулалт, довжоо	ББ-4
5	Хучилтын байгуулалт	ББ-5
6	Шувуун нурууны байгуулалт, ул нурууны бэхэлгээ, саравчны хэсэглэл	ББ-6
7	Модон татанга түүвэр	ББ-7
8	Хэсэглэл - А	ББ-8
9	Хэсэглэл - Б, В	ББ-9
10	Хэсэглэл - Г, Д	ББ-10
11	Хэсэглэл - Е, Ж	ББ-11

ТАЙЛБАР БИЧИГ:

Байршил: Увс аймаг Сагил сумын Өндөр мод баг

Өгөгдөл:

Уг барилгыг норм дүрмийн дагуу, Увс аймгийн Засаг даргын тамгын газрын захиалгаар " Сагил сумын Өндөр мод багийн төв"-ын барилгын ажлын зураг төсөл боловсруулах 2018.03.06-ны дугаар / ЗТ-05/2018/-тоот зургийн даалгаварыг үндэслэн барилгын зураг төслийг барилгын зураг төслийн " БАРИЛГЫН ИНЖЕНЕРҮҮД" ХХК-д боловсруулав.  
Төлөвлөж буй барилга нь 1 давхар 0.00-3.00м, тэнхлэгийн харьцаа 14x8м.

Байгаль цаг уурын үндсэн өгөгдөл :

- Газар хөдлөлийн балл :
- Гадна агаарын тооцоот температур: -38.5°C
- Цасны ачаалал: 50кг/м2
- Галд тэсвэрлэлтийн зэрэг : 2
- Салхины ачаалал: 42кг/м2
- Барилгын галын ангилал: II
- Гадна агаарын хэм хүйтний улиралд: -43°C
- Галалгааны үеийн дундаж температур: -9.7°C
- Галалгааны үеийн үргэлжлэх хугацаа: 223хоног

СУУРИЙН БАЙГУУЛАЛ М1:100

**Суурь:** Уг барилгыг цутгамал шугаман суурьтайгаар төлөвлөв.

Суурийн босоо ус тусгаарлагчийг суурийн газартай харьцах хэсэгт халуун хар тосоор 2 дахин түрхлэг хийж гүйцэтгэнэ. Суурийн эргэн тойрон чигжих шороог овойлт үзүүлдэггүй 40:60 харьцаатай элс хайргаар чигжинэ. Гадна ханын суурийн дээд хэсгийг цутгамал төмөр бетон бүсээр холбож өгнө. Суурийн ажил хийхийн өмнө автрын хяналт хийлгэх.

**Хана:** Гадна дотор хамар хануудыг 75 маркийн тоосго 50 маркийн цементэн зуурмагаар гагнана. Ханын булан уулзвар хамар хануудад өрлөгийн өндөрийн 8 үе тутамд өрлөгийн тор тавьж өгнө. Хамар ханыг зургийн дагуу бэхлэж өгнө. ББ-3 зургаас үз.

**Ялуу:** Цонх ба нүхний өргөн 1.5 м хүртэл бол 250 мм 1.5м-ээс дээш бол 350 мм -ээс багагүй суулгаж өгнө. Ялууг жигд тараагдсан бэхжээгүй В7.5 маркийн бетон зуурмаг дээр угсарна.ББ-4 зураг үз.

**Хучилт:** Модон татанга, модон батбайгаар хучина.Яндангийн нүх гаргахдаа 500x500 харьцаатай галд шатдаггүй материал (гленгрид) яндангийн диаметртай нүх гаргаж хучилтын модон бамбайнд бэхлэнэ.

**Модон татанга:** Модон татангыг ББ-7-ББ-11 хуудас зургийн дагуу угсарч гүйцэтгэнэ. Ул нурууг суулгахдаа ул нурууны доор уртын дагууд 1 үе толь хар цаас тавьж өгнө. Бүх модон хийцүүдэд өмхрөлт ба ялзралтаас сэргийлэх антисептик, гал шатахаас хамгаалах антипирен түрхлэг хийж өгнө. Модон материалын чийглэг нь 15%-аас ихгүй байна. Дээвэр 158.46м2 гөлмөн төмрөөр хучина.

**Хаяавч:** Барилгын эргэн тойронд 0.8м өргөнтэй бетон хаяавчыг барилгын сууриас гадагш нь налуутай / i=0.03/ хийнэ. 2.78м3